



ХААН БАНК

ХХД-9007001013
ХААН БАНК ЦАМХАГ
Чингисийн өргөн чөлөө-6,
Стадион Оргил-1, Хан-Уул
дүүрэг, Улаанбаатар 17010,
Монгол Улс
Утас: (976)-75153333
Факс: (976)-70117023
www.khanbank.com

2025 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Ж.ПИТЕР МОРРОУГИЙН НЭРЭМЖИТ ХААН БАНКНЫ ОЛИМПИАДАД ОРОЛЦОХ УРИЛГА

Эрхэм хүндэт Танаа,

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Питер Морроугийн нэрэмжит ХААН Банкны олимпиад"-д их дээд сургуулиудад банк, санхүүгийн чиглэлээр суралцаж буй 3,4-р дамжааны оюутнуудыг оюун ухаан, эрдэм мэдлэгээ уралдуулахыг урьж байна.

Энэхүү олимпиад нь энэ жил 12 дах удаагаа зохион байгуулагдаж буй бөгөөд үе үеийн оролцогчид томоохон банк, санхүүгийн байгууллагуудад ур ухаанаараа түүчээлэн ажиллаж буй нь бахархалтай.

Олимпиад 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр 10:00-17:00 цагийн хооронд ХААН Банк, Сүүл оффис, 1 давхар, Театрт зохион байгуулагдах тул урилгыг хүлээн авч, оюутнуудаа бэлтгэн оролцуулахыг хүсье.

Олимпиадын удирдамжийг хавсралтаар илгээлээ.

Хүндэтгэсэн,

ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



Батлав: /Ш.Ганбямба/

Хүний нөөц хариуцсан дэд захирал

Ж.ПИТЕР МОРРОУГИЙН НЭРЭМЖИТ ХААН БАНКНЫ ОЛИМПИАДЫН УДИРДАМЖ

2025 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Зорилго:

Монгол Улсад банк, санхүүгийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийн оюутнуудын мэдлэг, ур чадварыг хөгжүүлж, ирээдүйн чадварлаг боловсон хүчнийг нээн илрүүлэх зорилготой.

Оролцогчид:

Оролцогчид нь Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг их, дээд сургуулийн оюутан (*ганцаарчилсан болон багийн төрөлд*) байна. Улаанбаатар хотын хувьд, нэг сургуулиас **2-оос** дээшгүй баг оролцох боломжтой. Орон нутаг дахь салбар сургуулийн хувьд, тусдаа баг бүрдүүлж оролцох боломжтой.

Багт тавигдах шаардлага:

- Баг тус бүр 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.
- Багийн гишүүд тухайн сургуулийнхаа 3, 4-р дамжааны оюутан байна.
- Ганцаарчилсан төрөлд зөвхөн багийн гишүүд оролцоно. (*Багт ороогүй оюутан ганцаарчилсан төрөлд оролцох боломжгүй.*)

Олимпиадын хөтөлбөр:

№	Хөтөлбөр	Огноо	Цаг	Хаана
1	Бүртгэл	2025.05.05 хүртгэл		И-мэйл
2	Техникийн зөвлөгөөн	2025.05.06	16:00	Microsoft Teams програмаар явагдана.
3	Тестийн шалгалт, НББ-н нэгдсэн бодлого (Хувийн төрөл)	2025.05.08	10:00-12:00	Сөүл театр*
4	Кейс ажиллавар - 1, 2 (Багийн төрөл)	2025.05.08	13:00-15:30	
5	Тэргүүлэгч 5 баг шүүгчдэд кейс ажиллавар танилцуулах	2025.05.08	15:30-17:00	
6	Олимпиадын дүнг танилцуулах	2025.05.08	17:00	

*СБД 4-р хороо, Сөүлийн гудамж-25 Сөүл оффис буюу Хүүхдийн 100 ХААН Банк 1 давхарт, Театр

Тайлбар:

- Кейс хамгаалах: Хоёр кейс ажиллаврын нийлбэр дүнгээр өндөр оноотой 5 баг 10 минутад багтаан танилцуулга хийж 10 минутад асуултад хариулна. Танилцуулга хийх дарааллыг сугалаагаар шийдвэрлэнэ.
- Техникийн зөвлөгөөний үеэр олимпиадын хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө.

Тест шалгалтын сэдвүүд:

- Банкны менежмент
- Зээлийн шинжилгээ
- Эрсдэлийн менежмент
- Мэргэжлийн англи хэл
- Банкны нягтлан бодох бүртгэл
- Банкны тухай хууль, журам
- Бусад

Шалгалтын материалыг олимпиадыг зохион байгуулах ажлын хэсгийн гишүүд боловсруулна.

Багуудыг дүгнэх:

- Кейс ажиллагаа 60%
- Илтгэл 15%
- Кейс хамгаалалт 25%

Шагнал урамшуулал:

Багийн төрөлд:

I байр - Цом, өргөмжлөл, 3,000,000 төгрөг

II байр - Цом, өргөмжлөл, 2,000,000 төгрөг

Ганцаарчилсан төрөлд:

I байр - Өргөмжлөл, мөнгөн шагнал

II байр - Өргөмжлөл, мөнгөн шагнал

III байр - Өргөмжлөл, мөнгөн шагнал

Эхний 5 байрт шалгарсан оюутнуудад **ХААН Банканд ажилд орох урилга** (Хэрэв 3-р дамжааны оюутан бол ажилд орох урилга нэг жилийн хугацаанд хадгалагдана).

Жич: Ганцаарчилсан төрөлд оролцогчдын оноо тэнцсэн тохиолдолд байр эзлүүлэх шалгуур нь НББ-н нэгдсэн бодлогоор авсан оноо байна.

Багийн болон хувийн дүнгээр тэргүүлсэн сургууль Шилжин явах цомын эзэн болно.

Бүртгэл:

Олимпиадад оролцох оюутнуудын бүрдүүлэх материал:

- Иргэний үнэмлэх
- Оюутны үнэмлэх
- Багийн бүх гишүүнийг багтаасан сургуулийн тодорхойлолт зэргийг сканердаж, бүртгэлийн хуудасны хамтаар recruiters@khanbank.com хаяг руу ирүүлнэ. Бүртгэл ирүүлсэн и-мэйл хаяг руу техникийн зөвлөгөөний хурлын холбоосыг хүргүүлнэ.

*Бүртгэлийн хуудасны загвар :

Сургуулийн нэр	Багийн нэр	Удирдагч багш	Багийн гишүүдийн Овог нэр	Суралцаж буй чиглэл	Курс	И-мэйл хаяг	Холбоо барих утас
Сургуулийн нэр	Багийн нэр	Удирдагч багшийн нэр	Багийн гишүүн 1	Суралцаж буй чиглэл	Курс	Холбоо барих и-мэйл хаяг 1 Холбоо барих и-мэйл хаяг 2 (Сургуулийн и-мэйл хаяг байх)	Холбоо барих утас 1
Сургуулийн нэр	Багийн нэр	Удирдагч багшийн нэр	Багийн гишүүн 2	Суралцаж буй чиглэл	Курс		Холбоо барих утас 2
Сургуулийн нэр	Багийн нэр	Удирдагч багшийн нэр	Багийн гишүүн 3	Суралцаж буй чиглэл	Курс		Холбоо барих утас 3
Сургуулийн нэр	Багийн нэр	Удирдагч багшийн нэр	Багийн гишүүн 4	Суралцаж буй чиглэл	Курс		Холбоо барих утас 4
Сургуулийн нэр	Багийн нэр	Удирдагч багшийн нэр	Багийн гишүүн 5	Суралцаж буй чиглэл	Курс		Холбоо барих утас 5

Анхаарах зүйлс:

- Материал дутуу ирүүлсэн баг болон оюутныг бүртгэхгүй.
- Олимпиадад хүрэлцэн ирэхдээ цахим үнэмлэх болон оюутны үнэмлэхээ заавал авч ирнэ.
- Бичиг баримтгүй ирсэн тохиолдолд олимпиадад оролцох боломжгүй.
- Бүртгэлийн хуудас бөглөхдөө нэг багаас холбоо барих 2 имэйл, холбоо барих 2 утасны дугаар бүртгүүлнэ.

Бусад: Олимпиадын зааварчилгаа болон бусад асуудлуудыг техникийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

Холбоо барих:

Б.Батсүх: 9901-9786
О.Оюунболор 9929-4865

ХАМТДАА МЭДЛЭГЭЭ ӨСГӨӨ